

# ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ЖУРАМ

## НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдээс Хорооны мэдээллийн сан (цаашид “мэдээллийн сан” гэх)-д ирүүлэх мэдээллийн төрөл, хуваарь, түүнийг боловсруулах, хянах, ашиглах, хадгалахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд нь энэхүү журамд заасан мэдээллийг үнэн зөвөөр, тогтоосон хугацаанд маягтын дагуу гаргаж бичгэн болон цахим /moh@fsc.mn/ хэлбэрээр Хороонд ирүүлнэ.

1.3. Мэдээллийн санг бүрдүүлэх, боловсруулах, хянах, ашиглалтыг Үнэт цаасны газрын Мэргэжлийн оролцогчдын хэлтэс, мэдээллийн хадгалах, найдвартай байдлыг Хорооны Мэдээлэл технологийн хэлтэс тус тус хариуцна.

1.4. Энэ журамд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.4.1. “зохицуулалттай этгээд” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан үнэт цаасны арилжаа эрхлэх, үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага, брокер, дилер, андеррайтер болон хөрөнгө оруулалтын зөвлөх компанийг;

1.4.2. “мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн” гэж Үнэт цаасны газрын Мэргэжлийн оролцогчдын хэлтсийн хянан шалгагчийг;

1.4.3. “мэдээллийн сан хариуцсан ажилтан” гэж зохицуулалттай этгээдийн дотоод хяналтын ажилтныг. /Энэ заалт нь үнэт цаасны арилжаа эрхлэх, төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллагад хамаарахгүй/

## ХОЁР. Мэдээллийн төрөл, ирүүлэх хуваарь

2.1. Зохицуулалттай этгээдийн мэдээллийн сан хариуцсан ажилтан мэдээллийн төрлийг энэхүү журмын хавсралтаар баталсан маягтын дагуу Хороонд ирүүлэх үүрэгтэй.

2.2. Үнэт цаасны арилжаа эрхлэх болон үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага нь мэдээллийн санд ирүүлэх тухайн сарын мэдээллийг дараа сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ.

2.3. Брокер, дилер, андеррайтер болон хөрөнгө оруулалтын зөвлөх компани нь мэдээллийн санд ирүүлэх тухайн улирлын мэдээллийг дараа сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ.

2.4. Зохицуулалттай этгээдийн мэдээллийн сан хариуцсан ажилтан нь энэхүү журмын 2.2, 2.3-д заасан хуваарийн дагуу мэдээллийг мэдээллийн санд ирүүлэхээс гадна холбогдох мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд ажлын 10 өдөрт багтааж тухай бүр шинэчлэн ирүүлнэ.

## **ГУРАВ. Мэдээллийн санд мэдээлэл хүлээн авах, боловсруулах, хяналт тавих**

3.1. Мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн мэдээллийн санд ирүүлсэн мэдээллийг дараахь байдлаар хянана. Үүнд:

- 3.1.1 мэдээллийг үнэн зөв, тогтоосон хугацаанд гаргасан эсэх;
- 3.1.2 тухайн мэдээллийг өмнө нь өгч байсан бол түүнтэй нийцэж буй эсэх;
- 3.1.3 мэдээллийг маягтын дагуу бүрэн ирүүлсэн эсэх;
- 3.1.4 шаардлагатай гэж үзсэн бусад ажиллагаа.

3.2. Мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн нь ирүүлсэн мэдээлэл энэхүү журмын 3.1-д зааснаар хянаж, нөхцлийг хангасан тохиолдолд бичгээр ирүүлсэн баримтыг тухайн зохицуулалттай этгээдийг хариуцсан хянан шалгагчид ажлын 2 хоногийн дотор хүлээлгэн өгнө.

3.3. Мэдээллийн санд ирүүлсэн мэдээлэлтэй холбоотой зайны хяналтыг Хорооны зохицуулалттай этгээдийг хариуцсан хянан шалгагч гүйцэтгэх ба шаардлагатай тохиолдолд газар дээрх хяналт, шалгалтыг хэрэгжүүлнэ.

3.4. Маягтын дагуу гаргаагүй, бүрдэл дутуу ирүүлсэн тохиолдолд уг **мэдээллийг ирүүлсэнд** тооцохгүй.

## **ДӨРӨВ. Мэдээллийн сангийн мэдээллийг ашиглах**

4.1. Мэдээллийн сангийн мэдээллийг судалгаа шинжилгээ хийх, зохицуулах байгууллагын бодлогын болон хяналтын чиг үүргийг шуурхай, үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор ашиглана.

4.2. Мэдээллийн сангийн мэдээллийг 4.1-д зааснаас бусад зорилгоор ашиглахыг хориглоно.

4.3. Монголбанк, санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, шүүх, прокурор, цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажлын шаардлагаар тэдгээр байгууллагын удирдлагын бичгээр хүсэлт гаргасан тохиолдолд мэдээллийн сангаас холбогдох мэдээллийг хүргүүлнэ.

4.5. Мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн нь сангийн мэдээллийг улирал тутам эмхэтгэж, Хорооны удирдлагад танилцуулна.

## **ТАВ. Мэдээллийн сан дах мэдээллийн хадгалалт**

5.1. Мэдээллийг электрон хэлбэрээр мэдээллийн санд, цаасан хэлбэрээр тухайн зохицуулалттай этгээдийн хувийн хэрэгт хадгална.

5.2. Мэдээллийн сангийн аюулгүй байдлыг мэдээллийн сан хариуцсан болон Мэдээлэл, технологийн хэлтсийн мэргэжилтэн нар тус тус хариуцна.

## **ЗУРГАА. Хариуцлага**

6.1. Зохицуулалтын этгээдийн мэдээллийн сан хариуцсан ажилтны хууль тогтоомж, Хорооны шийдвэр болон энэ журмаар мэдээллийн санд ирүүлэхээр заасан мэдээллийг тогтоосон хугацаанд, зохих маягтын дагуу, үнэн зөвөөр, бүрэн ирүүлээгүй үйлдлийг зохицуулалттай этгээдийн зөрчил гаргасан үйлдэл нь тухайн компанид хариуцлага ногдуулах үндэслэл болно.

6.2. Зохицуулалттай этгээд нь өөрийн мэдээллийн сан хариуцсан ажилтны энэхүү журмын 6.1-д заасан үйлдлийг тухайн компанийн үйл ажиллагаа, удирдлагын шийдвэрээс шалтгаалаагүй, тухайн үйлдлийн сэдэлд ямар нэг холбоогүй гэдгээ нотолсон тохиолдолд зөрчил гаргасан зохицуулалттай этгээдийн уг ажилтанд хариуцлага ногдуулна.

6.3. Энэ журмын холбогдох заалтыг зөрчсөн нь тогтоогдвол зохицуулалтын этгээдийн мэдээллийн сан хариуцсан ажилтны үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрхийг хүчингүй болгож, зохицуулалттай этгээдийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэн, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан захиргааны хариуцлага хүлээлгэх бөгөөд цаашид захиргааны шийтгэлтэйд тооцогдох хугацаанд дахин зөрчил гаргасан тохиолдолд уг тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

## **ҮНЭТ ЦААСНЫ ГАЗАР**

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

		Сар бүр	Өссөн дүн
1	Арилжаа явагдсан өдөр		
2	Үнэт цаас нь бүртгэгдсэн компанийн тоо Үүнээс: Төрийн өмчийн Төрийн өмчийн оролцоотой Хувийн өмчийн		-
3	Бүртгэлтэй үнэт цаасны нийт тоо ширхэг Үүнээс: Төрийн өмчийн Хувийн өмчийн		
4	Зах зээлийн нийт үнэлгээ /төгрөг/		-
5	Арилжааны төрөл Үүнээс: Энгийн арилжааны үнийн дүн /төгрөг/ Багцын арилжааны үнийн дүн /төгрөг/ Тендер саналын арилжаа үнийн дүн /төгрөг/ AON дуудлага арилжаа үнийн дүн /төгрөг/		
6	Анхдагч зах зээлийн үнэт цаасны гүйлгээний дүн /төгрөг/ Үүнээс: Компанийн хувьцаа Засгийн газрын бонд /хоёрдогч зах зээлд/ Компанийн бонд <a href="#">Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа /нэгж эрх/</a> <a href="#">Хадгаламжийн бичиг</a> <a href="#">Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас</a> <a href="#">Үүсмэл санхүүгийн хэрэгсэл</a>		
7	Анхдагч зах зээлийн үнэт цаасны тоо ширхэг Үүнээс: Компанийн хувьцаа Засгийн газрын бонд Компанийн бонд <a href="#">Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа</a> <a href="#">Хадгаламжийн бичиг</a> <a href="#">Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас</a> <a href="#">Үүсмэл санхүүгийн хэрэгсэл</a>		

8	<p>Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн гүйлгээний дүн /төгрөг/          Үүнээс:Компанийн хувьцаа          Засгийн газрын бонд /хоёрдогч зах зээлд/          Компанийн бонд  <a href="#">Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа</a>  <a href="#">Хадгаламжийн бичиг</a>  <a href="#">Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас</a>  <a href="#">Үүсмэл санхүүгийн хэрэгсэл</a></p>		
9	<p>Хоёрдогч зах зээлд арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг          Үүнээс:Компанийн хувьцаа          Засгийн газрын бонд          Компанийн бонд  <a href="#">Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа</a>  <a href="#">Хадгаламжийн бичиг</a>  <a href="#">Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас</a>  <a href="#">Үүсмэл санхүүгийн хэрэгсэл</a></p>		
10	<p>Дундаж ханш          Үүнээс: Компанийн хувьцаа          Засгийн газрын бонд          Компанийн бонд  <a href="#">Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа</a>  <a href="#">Хадгаламжийн бичиг</a>  <a href="#">Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас</a>  <a href="#">Үүсмэл санхүүгийн хэрэгсэл</a></p>		
11	<p>ТОП-20 индекс          Дундаж          Хамгийн их          Хамгийн бага          Хаалт</p>		
12	<p>Арилжигдсан үнэт цаасны тоо          Үүнээс: Ханш өссөн          Ханш буурсан          Ханш тогтмол</p>		
13	<p>Хийгдсэн хэлцэл</p>		



ХАНШИЙН ХЭЛБЭЛЗЭЛ ИХТЭЙ ҮНЭТ ЦААС (ТУХАЙН САРД)  
ХАНШИЙН ӨСӨЛТТЭЙ ҮНЭТ ЦААС

№	Үнэт цаас	Арилжагдсан ширхэг	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт	Өөрчлөлт хувиар
			Сарын эхэнд	Сарын эцэст		
1						
2						
3						
4						
5						
6						
7						
8						
9						
10						

ХАНШИЙН БУУРАЛТТАЙ ҮНЭТ ЦААС

№	Үнэт цаас	Арилжагдсан ширхэг	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт	Өөрчлөлт хувиар
			Сарын эхэнд	Сарын эцэст		
1						
2						
3						
4						
5						
6						
7						
8						
9						
10						





"Зохицуулалттай этгээдийн мэдээллийн сангийн журам"-ын хавсралт МС-1-6 маягт

ҮНЭТ ЦААСНЫ КОМПАНИЙН ГҮЙЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ /тухайн сараар/

№	Гишүүн БДК-ийн нэр	Арилжаанд оролцсон өдөр	Авсан үнэт цаас		Зарсан үнэт цаас		Зөрчил гаргасан эсэх
			ширхэг	үнийн дүн	Тоо ширхэг	үнийн дүн	

"Зохицуулалттай этгээдийн мэдээллийн сангийн журам"-ын хавсралт МС-1-7 маягт

ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭГ БҮРДҮҮЛЭГЧ ХУВЬЦААТ КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ /САРААР/

№	Компанийн нэр	Үнэт цаасны тоо ширхэг	Тухайн сарын хаалтын ханш	Зах үнэлгээ

"Зохицуулалттай этгээдийн мэдээллийн сангийн журам"-ын хавсралт МС-1-8 маягт

ТОП-20 КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Компанийн нэр	Үнэт цаасны тоо ширхэг	Тухайн сарын хаалтын ханш	Зах зээлийн үнэлгээ

"Зохицуулалттай этгээдийн мэдээллийн сангийн журам"-ын хавсралт МС-1-9 маягт

ХӨРӨНГИЙН БИРЖ/ ҮНЭТ ЦААСНЫ ХАДГАЛАМЖИЙН БАЙГУУЛЛАГА/  
ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР ТООЦООНЫ БАЙГУУЛЛАГЫН  
ТАНИЛЦУУЛГА

№	Үзүүлэлтүүд	Мэдээлэл
	Улсын бүртгэлд бүртгүүлсэн огноо, гэрчилгээний дугаар	
	Тусгай зөвшөөрлийн огноо, дугаар	
	Байгуулагдсан огноо, шийдвэр	
	Өөрчлөн байгуулагдсан огноо, шийдвэрийн дугаар	
	Хувь нийлүүлсэн хөрөнгө, өмчийн хэлбэр, өмчлөгч	
	ТУЗ-ийн дарга: овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	ТУЗ-ийн гишүүд:	
	1. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	2. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	3. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	4. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	5. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	6. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	7. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	8. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	Гүйцэтгэх захирал: овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	Албадын захирлууд:	
	1. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	2. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	3. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	4. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	

Энэ мэдээг өөрчлөлт оруулсан тухай бүр ирүүлнэ.

"Зохицуулалттай этгээдийн мэдээллийн сангийн журам"-ын хавсралт МС-2-1 маягт

### ҮНЭТ ЦААСНЫ ХАДГАЛАМЖИЙН НЭГДСЭН МЭДЭЭЛЭЛ

Код	Үнэт цаасны нэр	Хувьцаа эзэмшигчдийн тоо			
		1-ээс дээш хувь	5-аас дээш хувь	10 -аас дээш хувь	33,3-аас дээш хувь

"Зохицуулалттай этгээдийн мэдээллийн сангийн журам"-ын хавсралт МС-2-2 маягт

### ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖИЙН БҮРТГЭЛИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

№	код	Үнэт цаасны нэр	Үнэт цаасны тоо (сарын эхэнд)	Бүртгэлд орсон өөрчлөлт		Үнэт цаасны тоо /сарын эцэст/	Тайлбар
				Нэмэгдсэн	Хасагдсан		







"Зохицуулалттай этгээдийн мэдээллийн сангийн журам"-ын хавсралт МС-2-5-5 маягт

КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖААНЫ БОЛОН ШИМТГЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ /анхдагч зах зээл/

Код	БДК-ийн нэр	Худалдан авсан			Худалдсан			МХБ-ийн шимтгэл	ҮЦТТГХТ-ийн шимтгэл	БДК-ийн шимтгэл	МХБ-ийн бүртгэлийн хураамж	СЗХ-ны зохицуулалтын үйлчилгээний хөлс
		Ширхэг	Үнийн дүн	Шимтгэл	Ширхэг	Үнийн дүн	Шимтгэл					

"Зохицуулалттай этгээдийн мэдээллийн сангийн журам"-ын хавсралт МС-2-5-6 маягт

КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖААНЫ БОЛОН ШИМТГЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ /хоёрдогч зах зээл/

Код	БДК-ийн нэр	Худалдан авсан			Худалдсан			МХБ-ийн шимтгэл	ҮЦТТГХТ-ийн шимтгэл	БДК-ийн шимтгэл	СЗХ-ны зохицуулалтын үйлчилгээний хөлс
		Ширхэг	Үнийн дүн	Шимтгэл	Ширхэг	Үнийн дүн	Шимтгэл				



"Зохицуулалттай этгээдийн мэдээллийн сангийн журам"-ын хавсралт МС-2-6 маягт

**ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖИД НЭЭГДСЭН ДАНСНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ**  
/сараар болон өссөн дүнгээр/

№	БДК-ны код	Шинээр	Иргэд		ААН		Холболт	Нийт
			Монгол	Гадаад	Монгол	Гадаад		

"Зохицуулалттай этгээдийн мэдээллийн сангийн журам"-ын хавсралт МС-2-7 маягт

**ХУВЬЦААТ КОМПАНИЙН НОГДОЛ АШИГ/ХУВИЙН ТАРААЛТЫН ТАЙЛАН**

№	Компанийн нэр	Хувьцааны тоо		Ногдол ашиг/ хувийн хэмжээ /нэгж хувьцаанд.төг/		ногдол ашиг/ хувь авах эрхтэй хувьцаа эзэмшигчийн тоо	Тараасан хэлбэр			үлдэгдэл
		нийт гаргасан	ногдол ашиг /хувь/	нэгж хувьцаа	нийт		дансанд байршуулсан	Б/ДК-р	Компаниар	

"Зохицуулалттай этгээдийн мэдээллийн сангийн журам"-ын хавсралт МС-2-8 маягт

**КОМПАНИЙН БОНДЫН ХҮҮ  
ҮНДСЭН ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЭЛ**

Бондын төрөл	хугацаа	хүү (хямдралын хэмжээ)	нийт төлөгдөөгүй үлдэгдэл	төлөгдөх хугацаа болсон		төлөгдсөн	
				үндсэн төлбөр	хүү	үндсэн төлбөр	хүү

"Зохицуулалттай этгээдийн мэдээллийн сангийн журам"-ын хавсралт МС-2-9 маягт

ҮҮРГИЙН ГҮЙЦЭТГЭЛ ХАНГУУЛАХ ЗОРИЛГООР  
ЗЭЭЛИЙН БАРЬЦААНД ТУСГААРЛАСАН ҮНЭТ  
ЦААСНЫ МЭДЭЭ

зээлдэгчийн нэр		
зээлдүүлэгчийн нэр		
барьцаалсан үнэг цаас	код	
	нэр	
	тоо	
	код	
	нэр	
	тоо	
	код	
	нэр	
	тоо	
зээлийн	хэмжээ	
	хугацаа	
	хүү	

ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ШИЙДВЭРЭЭР  
ҮНЭТ ЦААС ТУСГААРЛАСАН БОЛОН ЧӨЛӨӨЛСӨН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

Огноо	Тусгаарласан болон чөлөөлсөн үнэт цаасны нэр	Үнэт цаасны эзэмшигчийн			Тоо ширхэг	Шимтгэл	Тайлбар
		Овог нэр	Регистр	Дансны дугаар			

"Зохицуулалттай этгээдийн мэдээллийн сангийн журам"-ын хавсралт МС-2-11 маягт

ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖИД ХАДГАЛАГДАЖ БУЙ ҮНЭТ ЦААС /МЯНГАН ШИРХЭГ/

Үзүүлэлт	Тухай сард	Өссөн дүн	
Төрийн мэдлийн бус хувьцаа			
Төрийн мэдлийн хувьцаа			
Орон нутгийн оролцоотой компани			
Нийт хувьцааны дүн			
Засгийн газрын хямдруулсан бонд			
Компанийн бонд			
Нийт бондын дүн			
Биржийн бус зах зээлд бүртгэлтэй үнэт цаас /мянган ширхэгээр/			
Компанийн бонд			
Засгийн газрын хямдруулсан бонд			

ГАДААД ДОТООДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АРИЛЖААНЫ ҮНИЙН ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ

	Гадаадын хуулийн этгээд	Гадаадын иргэн	Дотоодын хуулийн этгээд	Дотоодын иргэн	Нийт гүйлгээ /тэрбум төгрөг/
	Хийсэн гүйлгээ /тэрбум төгрөг/	Хийсэн гүйлгээ /тэрбум төгрөг/	Хийсэн гүйлгээ /тэрбум төгрөг/	Хийсэн гүйлгээ /тэрбум төгрөг/	
Тухайн сард					
Өссөн дүнгээр					

"Зохицуулалттай этгээдийн мэдээллийн сангийн журам"-ын хавсралт МС-3-1 маягт

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

№	Байгууллагын нэр	
1.	Үүсгэн байгуулагдсан огноо	
2.	Компанийн улсын бүртгэлийн болон гэрчилгээний дугаар	
3.	Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж бол гадаадын хөрөнгө оруулалтын гэрчилгээний дугаар	
4.	Тусгай зөвшөөрөл олгосон тогтоолын дугаар, гэрчилгээний дугаар	
5.	Үнэт цаасны арилжаа эрхлэх ямар байгууллагын гишүүн болох	
6.	Үнэт цаасны зах зээл дээр үйл ажиллагаа эрхлэх үйлчилгээний төрөл, явуулсан хугацаа	
7.	Компанийн хувьцаа эзэмшигчдийн нэрс, эзэмшиж буй хувьцааны тоо ширхэг, хувь, нэрлэсэн үнэ	
8.	Орон нутагт салбар үйл ажиллагаа эрхэлдэг эсэх / аймаг, сум/	
9.	Нийт харилцагчийн тоо	
10.	ТУЗөвлөлийн дарга, гишүүдийн танилцуулга, /овог нэр, гэрийн хаяг, утас, e-mail /мэргэжил, ажлын туршлага	
11.	Гүйцэтгэх захиралын танилцуулга: /овог нэр, мэргэжлийн үнэмлэхийн дугаар, дуусах хугацаа, утас, e-mail мэргэжил, өмнө эрхэлж байсан ажил, албан тушаал	
12.	Компанийн хаяг байршил, холбоо барих утас, цахим хаяг,	
13.	Сүүлийн 3 жилд арилжааны хэлцэл буцаагдаж байсан эсэх. / тийм, үгүй аль нэгийг сонгох ямар шалтгаанаар буцаагдсан талаар тайлбар бичих.	
14.	Сүүлийн 3 жилд Хороо, Хөрөнгийн биржээс компани болон ажилтанд хариуцлага хүлээлгэж байсан эсэх. / хүлээлгэсэн огноо, шийтгэлийн төрөл, ямар зөрчилд оногдуулсан тайлбар/	

Энэ мэдээг өөрчлөлт оруулсан тухай бүр ирүүлнэ.

"Зохицуулалттай этгээдийн мэдээллийн сангийн журам"-ын хавсралт МС-3-2маягт

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ АНДЕРАЙТЕР, БРОКЕР, ДИЛЕР,  
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗӨВЛӨХ КОМПАНИЙН МЭРГЭЖИЛТНИЙ  
ТАНИЛЦУУЛГА

№	Регистрийн дугаар	Овог	Нэр	Албан тушаал	Төгссөн сургууль, мэргэжил	ҮЦЗЗ дээр ажил үйлчилгээ явуулах эрхийн үнэмлэхний дугаар, дуусах хугацаа	Холбоо барих утас

"Зохицуулалттай этгээдийн мэдээллийн сангийн журам"-ын хавсралт МС-3-3маягт

АНДЕРРАЙТЕРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

Үйлчлүүлэгчийн нэр	Үзүүлэхээр гэрээ байгуулсан үйлчилгээний хэлбэр	Бусад этгээдтэй хамтран ажиллах гэрээ байгуулсан бол	
		Хамтран ажиллах чиглэл	Этгээдийн нэр

Андеррайтерийн үйлчилгээний гэрээний биелэлтийн тухай мэдээлэл:

---



---



---



---



---

"Зохицуулалттай этгээдийн мэдээллийн сангийн журам"-ын [хавсралт МС-3-4 маягт](#)

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗӨВЛӨХ КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ**

Д/Д	Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ үзүүлсэн ААН	Үйлчилгээний төлбөрийн хэмжээ	Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ үзүүлсэн иргэн	Үйлчилгээний төлбөрийн хэмжээ

"Зохицуулалттай этгээдийн мэдээллийн сангийн журам"-ын хавсралт МС-3-5 маягт

**ДИЛЕРИЙН КОМПАНИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГӨӨР ХИЙСЭН АРИЛЖААНЫ МЭДЭЭЛЭЛ**

Худалдан авсан			Худалдсан		
Үнэт цаасны нэр	тоо	үнийн дүн	Үнэт цаасны нэр	тоо	үнийн дүн



КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН,  
АЖИЛТНУУДЫН НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДИЙН  
ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

	Эрх бүхий албан тушаалтан, ажилтны овог нэр	албан тушаал	төвлөрсөн хадгаламж дахь дансны дугаар	Холбогдох этгээдүүдийн /эхнэр, нөхөр, хүүхэд гэх мэт/ овог,нэр	төвлөрсөн хадгаламж дахь дансны дугаар
1		ТУЗ-ийн дарга, гүшүүд			
2		Гүйцэтгэх захирал			
3		Брокер, дилер, хөрөнгө оруулалтын зөвлөх гэм мэт			

Тайлбар: Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан ажилтанд ТУЗ-ийн дарга, гишүүд, гүйцэтгэх болон бусад захирлууд, газар хэлтэс, тасаг албадын дарга нар салбар төлөөлөгчийн газрын дарга нар, ажилтанд брокер, дилер, нягтлан бодогчоор ажиллаж буй хүмүүс хамаарна.

КОМПАНИЙН САЛБАР /ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР/ -ИЙН МЭДЭЭЛЭЛ

Д/Д	Код	Компанийн нэр	Үйлчилгээ үзүүлэх эрхтэй орон нутаг	Компанийн үндсэн хаяг, утас	Салбарын хаяг	Салбарын захирлын нэр, холбоо барих утас	Брокерийн нэр, холбоо барих утас